

“АРКАЗИА 2021” ОЛОН УЛСЫН УРАЛДААНД ОРОЛЦОХ ҮНДЭСНИЙ ШИЛДГҮҮДИЙГ ШАЛГАРУУЛНА

Architects' Regional Council Asia (ARCASIA) буюу Азийн бүсийн Архитекторуудын зөвлөл (АБАЗ)-өөс уламжлал болгон зохион байгуулдаг уралдаанд Монгол Улсыг төлөөлж оролцох шилдэг гурван оролцогчийг шалгаруулах уралдааныг Монголын архитекторуудын эвлэл (МАЭ)-ээс зохион байгуулах гэж байна. Иймд уг тэмцээнд идэвхтэй оролцохыг “СИТИ” Их сургуулийн оюутнууддаа уриалж байна.

АБАЗ нь Азийн 21 орны мэргэжлийн хүрээлэнгүүдийг эгнээндээ нэгтгэсэн байгууллага бөгөөд архитектур ба хүний гараар бүтсэн орчныг сайжруулан хөгжүүлэх, цаашлаад хүн төрөлхтний өмнө тулгамдаад буй асуудлуудыг шийдвэрлэхэд нэгдэн ажиллах зорилготойгоор жил бүр өгөгдсөн сэдвийн дагуу олон улсын арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулж иржээ.

Уралдааны эхний шатыг гишүүн байгууллагууд эх орондоо зохион байгуулдаг бөгөөд Монгол Улсын төлөөлөн оролцох **үндэсний шилдэг гурван оролцогчийг** дараах байдлаар тодруулна.

1. Уралдаанд оролцогч

МАЭ-ийн гишүүн их, дээд сургуулийн бакалаврын зэрэг олгох сургалтад суралцаж буй оюутан ба оюутнуудын баг байна. Багийн гишүүдийн тоонд ямар нэг хязгаарлалт байхгүй.

2. Бүтээл хүлээн авах

2021 оны 06 дугаар сарын 30 (лхагва гараг)-ны өдрийн 23 цаг 59 минут.

Maе.architalk@gmail.com хаягаар ирүүлнэ.

3. Уралдааны сэдэв

“Бидний-Орчин-миний гэрээс 15 минутын амьдралын хүрээ”

Өөрийн гэрээс 15 минут хэвийн хурдаар алхаад хүрэх цэгүүдийг холбоход үүссэн талбай доторх амьдралын орон зайг дүрслэх юм. Энэ нь хувь хүний ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрийн хувьд биеийн онцлог, өдөр тутмын амьдралын хэмнэл, нийгмийн онцлог шинжийн тусгал байдаг. Оролцогчид орчноо анхааралтай ажиглан, тулгамдаж буй асуудлуудыг тодруулж, хөтөлбөр санаачлан, зохистой шийдлийг санал болгохыг зөвлөж байна.

4. Тавигдах шаардлага

- Сэдвийн хүрээнд өөрийн гэрийг төв болгосон 15 минут алхмын зайд байх орчноо ажиглаж, судалсны үндсэнд боловсруулсан ямар ч түвшний цар хүрээг хамарсан шийдэл байж болно. Жишээлбэл, хотын нийтийн байгууламжийн сэргээн засварлалт, цэцэрлэгжүүлэлт, хөршийн холбоог сэргээх сэдэлжүүлэлтийн инстоляци, хотыг хүүхдүүдэд ээлтэй болгон дахин төлөвлөх гэх мэт.

- Зургийн бүрдэлд зохих масштабтай дараах зургууд байна

А. План зургууд. Байршлын төлөвлөлт, талбайн төлөвлөлт, блокийн төлөвлөлт, барилга байгууламжийн байгуулалт.

Б. Хөндлөн огтлол. Хамгийн багадаа нэг хөндлөн огтлол оруулах ба концепцоос хамааран өндөржилтийн зураг байж болно.

- Дэвшүүлж буй санаа, шийдлийг график, диаграмм, гар болон фото зураг ашиглан тайлбарласан байна. Фото зургийн хувьд зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх.

- А1 (841x594 mm) хөндлөн форматтай нэг нүүр байна. Файл хэлбэр (*.jpeg, *.pdf)-ээр хүлээн авна.
- Шийдлийнхээ гол санааг 500 үгт багтаан илэрхийлсэн тайлбар бичгийг А4 босоо форматаар файл (*.docs, *.pdf)-ээр илгээх. Үсгийн хэмжээ 12pt, мөр хоорондын зай 1.5, Times New Roman фонтоор бичсэн байх.
- Оролцогчдын бүртгэлийн хуудсийг бөглөж хавсаргана.

5. Зохиогчийн эрх

Оюутны өмчийн эрх нь зохиогч (зохиогчид) хамаарах боловч бүтээлээ ирүүлснээр МАЭ болон АБАЗ-ийн үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах зорилготой хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд ашиглаж болохыг хүлээн зөвшөөрч, зөвшөөрөл олгож байгаага баталгаажуулсан мэдэгдэл хийсэн үйлдэл гэж үзнэ.

6. Уралдааны олон улсын шалгаруулалт хүртэлх арга хэмжээнүүдийн хугацаа

2021 оны 05 сарын 31	Уралдааны зарыг түгээх
Уралдааны сэдэвтэй холбогдуулан туршлагатай менторуудаас зөвлөгөө авах	
2021 оны 06 сарын 07	Үндэсний шилдгүүдийг тодруулах тэмцээнд оролцогчдыг тодруулах уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүнийг зарлах
2021 оны 06 сарын 30	Бүтээл хүлээн авах эцсийн хугацаа
2021 оны 07 сарын 07	Үр дүнг оролцогчдод танилцуулна
2021 оны 08 сарын 01	АБАЗ-ийн гишүүн байгууллагуудаас уралдаанд оролцох хүсэлтийг хүлээн авах сүүлийн хугацаа
Уралдаан зохион байгуулах ажлын хэсэг болон туршлагатай менторууд багуудад зөвлөгөө өгч, дэмжин ажиллана	
2021 оны 09 сарын 01	Үндэсний хэмжээний гурван шилдэг оролцогчийн мэдээллийг АСА19 багт ирүүлэх сүүлийн хугацаа
2021 оны 10 сарын 1	Олон улсын уралдааны ялагчид тодорно
2021 оны 10 сарын 31	Олон улсын уралдааны дүнг нийтэд зарлана

Олон улсын уралдааны дүнг олон нийтэд зарлах хүртэл оролцож байгаага бусдад мэдэгдэхгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авах үүрэг хүлээнэ.

7. Шалгаруулалт ба Урамшуулал

МАЭ-ийн удирдах зөвлөлийн хуралдаанаар томилсон уралдааныг дүгнэх, шүүх үүрэг бүхий комиссын гишүүд уралдаанд ирүүлсэн бүтээлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч, дүгнэнэ. Бүх уралдаанд оролцогчдод батламж олгох бөгөөд дараагийн шатанд шалгарсан шилдэг оролцогчид нь менторуудаас зөвлөгөө авч бүтээлээ улам сайжруулах боломжтой.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Уралдааны сэдвийг судалж ойлгон ажилласан байдал	30
2	Дэвшүүлсэн санаа, шийдлийн шинэлэг байдал	50
3	Ажлын бүрдлийн шаардлагуудыг хангасан байдал	20
Нийт дүн		100

8. Нууцлал ба шударга өрсөлдөөн маргаан

- Оролцогчоос ирсэн ажлууд тусгай програм ашиглан шифрлэгдэнэ.
- Оролцогчийг ялган таньж болохуйц ямар нэгэн график дүрслэл ба таних тэмдгийг бүтээлд тусгаж болохгүй.
- Олон улсын уралдаан зохион байгуулагчийн зүгээс уралдааны үр дүнг олон нийтэд зарлах хүртэл тэмцээнд оролцож буй бүтээл болон тэмцээний шалгаруулалтад хөндлөнгөөс нөлөөлөх нөхцөл бүрдэхгүй байх үүднээс нууцлалыг чанд сахих.
- Сонгон шалгаруулалттай холбоотой комиссын шийдвэр эцсийнх байна. Олон улсын уралдаан зохион байгуулах удирдамжийн жишгийн дагуу оролцогчид давж заалдах, өгсөн үнэлгээ болон тэмдэглэлийг үзэх хүсэлт гаргах эрх олгогдохгүй.